



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/05

Баян-Овоо сум

Ёс зүйн дэд хороог байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Засгийн Газрын 2019 оны 33 дугаар тогтоол Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Монгол улсын ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоол, БСШУСайдын 2008 оны А/243 дугаар тушаал Ерөнхий Боловсролын Сургууль, Цэцэрлэгийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрмийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн дэд хорооны дарга: М.Энхжаргал – Арга зүйч

Гишүүдэд: Д.Бямбатогоо-Багш

Н.Ундармаа-туслах багш

2. Цэцэрлэгийн ёс зүйн дэд хорооны ажлын төлөвлөгөөг гаргаж төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх ба ёс зүйн дэд хорооны ажлыг төлөвлөгөөний дагуу улирал бүр хамт олонд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч М. Энхжаргал болон гишүүдэд үүрэг болгосугай.

3. Уг тушаал гарсантай холбогдуулан 2020 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн А/13 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЭРХЛЭГЧ



Ц.ЭНХМАА